



2020 оны 12 дугаар сарын 11
№46 /1148/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

ᠲᠦ᠋ᠷᠢᠢᠨ
ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ
ᠤᠯᠤᠰ
ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ
ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ



تاسکاس

پسرنفخ اميمو مر نسين

پسرنفخ اميمو مر نسين
پسرنفخ اميمو مر نسين

79707

• 970

پسرنفخ اميمو مر نسين

پسرنفخ اميمو مر نسين
پسرنفخ اميمو مر نسين

79707

• 970

پسرنفخ اميمو مر نسين

پسرنفخ اميمو مر نسين
پسرنفخ اميمو مر نسين

99707

• 770

پسرنفخ اميمو مر نسين

پسرنفخ اميمو مر نسين
پسرنفخ اميمو مر نسين

99707

• 970



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

486. Санхүүжилтийн хэлэлцээр соёрхон батлах тухай 2367

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

487. Элчин сайдыг эгүүлэн татах,
тохоон томилох тухай Дугаар 130 2368

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

488. Журам батлах тухай Дугаар 130 2369

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

489. “Онцгой байдлын үеийн дэмжлэг
болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл” 2375



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 10 дугаар
сарын 29-ний өдөр

Улаанбаатар
хот

САНХҮҮЖИЛТИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс болон Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд 2020 оны 9 дүгээр сарын 07-ны өдөр байгуулсан “Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл”-ийн Санхүүжилтийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Үндэсний мөхөөрөмж

Мөхөөрөмж /МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР/ 2020 оны 10 сарын 29 өдөр

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР
2020 оны 10 сарын 29 өдөр

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2020 оны 10 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар 130

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасныг тус тус үндсэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Данийн Хаант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Зоригийн Алтайг эгүүлэн татаж, Монгол Улсаас Данийн Хаант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Түвдэндоржийн Жанабазарын томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 09 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 130

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Хүнсний тухай хуулийн 8.3, 8.5-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт, журмыг сурталчлан таниулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг холбогдох аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3. Энэ тогтоолыг 2025 оны 6 дугаар сарын 1-ний өдөр хүртэл хугацаанд дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД**

З.МЭНДСАЙХАН

Засгийн газрын 2020 оны
130 дугаар тогтоолын хавсралт

**СҮҮ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР, ЦЕХЭД ТЕХНИКИЙН
ЗОХИЦУУЛАЛТЫН ШААРДЛАГАД НИЙЦСЭН МАЛЫН ТҮҮХИЙ СҮҮ
НИЙЛҮҮЛСЭН МАЛЧИН, ЭРЧИМЖСЭН МАЛ АЖ АХУЙ ЭРХЛЭГЧДЭД
МӨНГӨН УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь өвлийн улирлын сүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх замаар хуурай сүүний импортыг бууруулах, хүн амын ундны сүүний хэрэгцээг тогтвортой, хүртээмжтэй хангахад оршино.

1.2.Энэ журмаар сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжүүлсэн мал аж ахуй эрхлэгчдэд мөнгөн урамшуулал олгохтой холбогдох харилцааг зохицуулна.

1.3.Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.3.1.“түүхий сүү”, “ундны сүү” гэснийг Засгийн газрын 2011 оны 304 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт”-д заасан утга, агуулгаар;

1.3.2.“малчин” гэснийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д зааснаар;

1.3.3.“эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч” гэснийг Тариалангийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7-д зааснаар;

1.3.4.“төлбөрийн баримт” гэснийг Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.14-т зааснаар;

1.3.5.“бүртгэлийн систем” гэснийг Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.18-д зааснаар.

1.4.Энэ журмыг харьяалах нутаг дэвсгэртээ сурталчлах, малчдад сургалт явуулах ажлыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар хариуцан зохион байгуулна.

1.5.Энэ журмын 2.1, 2.2-т заасан шаардлагыг хангасан сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү тушаасан малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшууллыг тухайн оны 11 дүгээр сарын 1-нээс дараа оны 3 дугаар сарын 31-нийг дуустал хугацаанд 1 литр тутамд таван зуун төгрөгөөр тооцож олгоно.

1.6.Мөнгөн урамшууллыг сүү бэлтгэн нийлүүлсэн тухайн сарын сүүлийн өдрөөр тасалбар болгон энэ журмын 3.3-т заасан үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид малын эрүүл мэндийн бүртгэл, мэдээллийн сангийн болон татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэл зэрэгт үндэслэн дараа сарын 20-ны өдрийн дотор бэлэн бусаар олгоно.

Хоёр. Малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч болон үйлдвэр, цехэд тавигдах шаардлага

2.1.Малын түүхий сүү нийлүүлэх малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч нь дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:

2.1.1.малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчийн “А” дансны мэдээлэл нь Үндэсний статистикийн хорооны тухайн жилийн мал тооллогын мэдээлэлд бүртгэгдсэн байх;

2.1.2.малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч нь үйлдвэр, цехэд малын түүхий сүү нийлүүлэх бүрт малыг мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тогтмол хамруулсан, эрүүл болохыг баталгаажуулсан мал эмнэлгийн гэрчилгээг сумын гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээс авч, малын эрүүл мэндийн бүртгэл, мэдээллийн санд бүртгэгдсэн байх;

2.1.3.татварын төлбөрийн баримтын цахим системд өөрийн нэр, регистрийн дугаараар бүртгэгдсэн байх;

2.1.4.нийлүүлэх сүү нь мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан “Үйлдвэр, цехэд малын түүхий сүү нийлүүлэх, худалдах үед мөрдөх эрүүл ахуй, ариун цэврийн заавар”-т тавигдсан малын түүхий сүү MNS 4228:2011 стандарт болон шаардлагыг бүрэн хангасан байх;

2.1.5.үйлдвэр, цехтэй малын түүхий сүү нэг жилийн хугацаанд бэлтгэн нийлүүлэх, гэрээ байгуулсан байх.

2.2.Үйлдвэр, цех нь дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:

2.2.1.Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5-д заасан үйл ажиллагааны дүгнэлттэй байх;

2.2.2.Хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2-т заасан стандарт, техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн зориулалтын барилга байгууламж, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, агуулах, тээврийн хэрэгсэлтэй байх;

2.2.3.сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг шалгах хяналтын хуудсаар дүгнэгдсэн байх;

2.2.4.сүү худалдан авсан, бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн, борлуулсан тухайгаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аж ахуйн

нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу санхүүгийн болон татварын тайланд тусган баталгаажуулсан байх;

2.2.5.малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчтэй малын түүхий сүү нэг жилийн хугацаанд нийлүүлэх, худалдан авах гэрээ байгуулан худалдан авсан байх;

2.2.6.сүүлийн 2 жилийн санхүүгийн болон татварын баталгаажуулсан тайланг ирүүлэх;

2.2.7.малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчээс малын түүхий сүү худалдан авах бүр Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4.1.13-т заасан төлбөрийн баримтыг үйлдэн татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд баталгаажуулсан байх.

Гурав. Урамшуулал олгох

3.1. Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мөнгөн урамшуулалд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн дүнгийн талаарх саналыг холбогдох тооцоо, судалгаа, шаардлагатай бусад материалын хамт санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж батлуулна.

3.2. Үйлдвэр, цех нь журмын 2.2.1-2.2.6-д заасан шаардлагыг хангасан баримт бичгийг бүрдүүлэн албан хүсэлтийн хамт тухайн жилийн 10 дугаар сарын 5-ны өдрийн дотор хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

3.3. Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь холбогдох төрийн байгууллагыг оролцуулан ажлын хэсэг байгуулж, энэ журмын 3.2-т заасан баримт бичгийг хянан үзэх замаар шаардлага хангасан үйлдвэр, цехийг сонгон шалгаруулж, жагсаалтыг батлан, хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын албан ёсны цахим хуудсанд тухайн жилийн 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор байршуулна.

3.4. Сумын гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээс малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид олгосон мал эмнэлгийн гэрчилгээний мэдээллийг сумын мал эмнэлгийн тасгаар баталгаажуулан сар бүрийн 25-ны өдрийн дотор мал, амьтны эрүүл мэндийн бүртгэл мэдээллийн санд илгээнэ.

3.5. Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь сумын мал эмнэлгийн тасгаас малын эрүүл мэндийн бүртгэл мэдээллийн санд илгээсэн мэдээллийг нэгтгэн, хянан баталгаажуулна.

3.6. Үйлдвэр, цех нь мал эмнэлгийн гэрчилгээг үндэслэн малын түүхий сүүг худалдан авна.

3.7. Үйлдвэр, цех нь малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчээс малын түүхий сүүг худалдан авах тухай бүр Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4.1.13-т заасан төлбөрийн баримтыг үйлдэн татварын цахим төлбөрийн баримтын системд бүртгэн баталгаажуулж, сар бүрийн сүүлийн өдөрт багтаан хоёр тал тооцоо нийлнэ.

3.8. Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь малын эрүүл мэндийн бүртгэл мэдээллийн сангийн мэдээлэл, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг үндэслэн энэ журамд заасан нөхцөл шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянан үзсэний үндсэн дээр урамшуулал олгох жагсаалтыг гарган, хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулж, шийдвэрлүүлнэ. Урамшууллыг төрийн сангийн дансаар дамжуулан малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид сүү нийлүүлэх, худалдах гэрээнд заасан нэрийн дансанд дараа сарын 20-ны дотор шилжүүлнэ.

3.9. Малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчийн дансанд шилжүүлсэн урамшуулал нь нэр, данс зөрсөн, данс хаагдсаны улмаас буцаагдсан тохиолдолд уг дансны жагсаалтыг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох аймаг, нийслэл, сум, дүүргийн хүнс, хөдөө ахуйн асуудал хариуцсан байгууллагад хүргүүлж залруулах арга хэмжээ авна.

3.10. Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь урамшуулалд шаардагдах хөрөнгийн зарцуулалт, урамшууллын санхүүгийн тайланг нэгтгэн боловсруулж, аудит хийлгүүлнэ.

Дөрөв. Урамшуулал олгохоос татгалзах

4.1. Дараах тохиолдолд урамшууллын санхүүжилт олгохгүй:

4.1.1. энэ журмын 3.3-т заасан жагсаалтад ороогүй үйлдвэр, цехэд сүү нийлүүлсэн;

4.1.2. бэлтгэн нийлүүлсэн малын түүхий сүүний худалдан авалт, борлуулалтын баримт нь татварын цахим төлбөрийн системд бүртгэгдэн баталгаажаагүй;

4.1.3. бэлтгэн нийлүүлсэн малын түүхий сүүнд олгосон мал эмнэлгийн гарал үүслийн гэрчилгээ нь малын эрүүл мэндийн бүртгэл мэдээллийн сангийн системд бүртгэгдэн баталгаажаагүй;



4.1.4. Үндэсний статистикийн хорооны тухайн жилийн мал тооллогын мэдээлэлд малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчийн “А” дансны мэдээлэл бүртгэгдээгүй;

4.1.5. бэлтгэн нийлүүлсэн малын түүхий сүү нь тухайн жилийн мал тооллогын “А” дансанд бүртгэгдсэн малын тоо, толгойд үндэслэн сүүний чиглэлийн үхрийн удам гарваль, ашиг шимийг тооцон гаргасан сүүний гарцын хэмжээнээс илүү гарсан тохиолдолд илүү гарсан сүүний хэмжээнд.

4.2. Холбогдох мэдээлэл буруу, бүртгэл дутуу байдлаас шалтгаалан урамшуулал олгогдоогүй тохиолдолд хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцлага хүлээхгүй.

Тав. Бусад

5.1. Энэ журмын 2.1.2, 3.7-д заасан мал эмнэлгийн гэрчилгээ, татварын цахим төлбөрийн баримтыг холбогдох журмыг зөрчиж, хуурамчаар үйлдэж олгосон мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч, үйлдвэрлэл эрхлэгч, аж ахуйн нэгж, байгууллагад холбогдох хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

САНХҮҮЖИЛТИЙН ДУГААР 6697-МОГ

МОНГОЛ УЛС

ба

ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АССОЦИАЦИ

ХООРОНДЫН

Санхүүжилтийн хэлэлцээр

(Монгол Улс: Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл)

САНХҮҮЖИЛТИЙН ХЭЛЭЛЦЭЭР

Энэхүү ХЭЛЭЛЦЭЭР нь МОНГОЛ УЛС (цаашид “Хүлээн авагч” гэх) болон ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АССОЦИАЦИ (цаашид “Ассоциаци” гэх)-ийн хооронд Хэлэлцээр байгуулж, гарын үсэг зурсан өдрөөр байгуулагдсан болно. Хүлээн авагч болон Ассоциаци нь дараах зүйлийг хэлэлцэн тохиролцов. Үүнд:

I ЗҮЙЛ - ЕРӨНХИЙ НӨХЦӨЛҮҮД, НЭР ТОМЬЁО

- 1.01. Ерөнхий нөхцөлүүд нь (тус Хэлэлцээрийн хавсралтад тодорхойлсон) энэхүү Хэлэлцээрт хамаарах бөгөөд Хэлэлцээрийн нэг хэсэг мөн.
- 1.02. Энэхүү Хэлэлцээрийн агуулгад өөрөөр заагаагүй бол Хэлэлцээрт том үсгээр бичсэн нэр томьёонууд нь Ерөнхий нөхцөлүүд болон энэхүү Хэлэлцээрийн хавсралтад тодорхойлсон утгыг илэрхийлнэ.

II ЗҮЙЛ - САНХҮҮЖИЛТ

- 2.01. Ассоциаци нь энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 1-т заасан төсөл (цаашид “Төсөл” гэх)-ийн санхүүжилтэд зориулан Хүлээн авагчид арван дөрвөн сая долоон зуун мянган Зээлжих Тусгай Эрх (ЗТЭ 14,700,000)-тэй тэнцэх хэмжээний, Ерөнхий нөхцөлүүдийн хувьд Хөнгөлөлттэй санхүүжилт хэмээн тооцогдох зээл (“Зээл” болон “Санхүүжилт” гэх)-ийг олгохоор тохиролцов.
- 2.02. Хүлээн авагч нь энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын III дахь хэсэгт заасны дагуу Санхүүжилтийн хөрөнгийг татан авч болно.



- 2.03. Санхүүжилтийн хөрөнгийн ашиглагдаагүй үлдэгдэлд Хүлээн авагчийн төлөх Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны жилийн хураамжийн дээд хэмжээ жилд нэг хувийн хагас (1%-ийн 1/2) байна.
- 2.04. Хүлээн авагчийн татаж авсан Зээлийн хөрөнгийн үлдэгдэлд төлөх Үйлчилгээний хураамж нь жилд нэг хувийн дөрөвний гурав (1%-ийн 3/4) байна.
- 2.05. Хүлээн авагчийн татаж авсан Зээлийн хөрөнгийн үлдэгдэлд төлөх Хүүгийн хураамж нь жилд нэг зууны хорин таван хувь (1.25%) байна.
- 2.06. Төлбөр хийх өдөр нь жил бүрийн 2 дугаар сарын 15-ны өдөр болон 8 дугаар сарын 15-ны өдөр байна.
- 2.07. Зээлийн үндсэн төлбөрийг энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 3-т заасан эргэн төлөх хуваарийн дагуу төлж барагдуулна.
- 2.08. Төлбөр хийх мөнгөн тэмдэгт нь ам.доллар байна.

III ЗҮЙЛ – ТӨСӨЛ

- 3.01. Хүлээн авагч нь Төслийн зорилтуудыг хангах үүрэг хүлээж байгаагаа үүгээр мэдэгдэж байна. Үүнтэй холбогдуулан Ерөнхий нөхцөлүүдийн V зүйл ба энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын дагуу, Хүлээн авагч нь уг төслийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамаар дамжуулан хэрэгжүүлнэ.

IV ЗҮЙЛ - ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ, ДУУСГАВАР БОЛОХ

- 4.01. Төсөл хүчин төгөлдөр болсон байх эцсийн хугацаа нь Хэлэлцээрт гарын үсэг зурснаас хойш нэг зуун наян (180) өдөр байна.
- 4.02. Ерөнхий Нөхцөлийн 10.05 (б) хэсэгт тусгасны дагуу Хүлээн авагчийн Хэлэлцээрийн үүрэг хариуцлага (төлбөрийн үүрэг, хариуцлагаас бусад) гарын үсэг зурсан өдрөөс хорин (20) жилийн дараа дуусгавар болно.

V ЗҮЙЛ - ТАЛУУДЫН ТӨЛӨӨЛӨГЧИД, ХАЯГ

- 5.01. Хүлээн авагчийн Төлөөлөгч нь тухайн үед санхүү, төсвийн асуудал хариуцсан Сайд байна.
- 5.02. Ерөнхий нөхцөлүүдийн 11.01 дэх хэсгийн хувьд: (а) Хүлээн авагчийн хаяг:

Сангийн яам
Засгийн Газрын II байр
С.Данзангийн гудамж 5/1 D
Улаанбаатар хот, 15160
Монгол Улс

ба
(b) Хүлээн авагчийн цахим хаяг:
Факс:
976-11-320247

5.03. Ерөнхий нөхцөлүүдийн 11.01 дэх хэсгийн хувьд: (a) Ассоциацийн хаяг:

International Development Association
1818 H Street, N.W.
Washington, D.C. 20433
United States of America; ба

(b) Ассоциацийн цахим хаяг:

Телекс: 248423 (MCI) Факс: 1-202-477-6391

Гарын үсэг зурсан өдөр ХАРИЛЦАН ТОХИРОВ.

МОНГОЛ УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ:

Эрх бүхий төлөөлөгч

Нэр: _____

Албан тушаал: _____

Огноо: _____

ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АССОЦИАЦИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Эрх бүхий төлөөлөгч

Нэр: _____

Албан тушаал: _____

Огноо: _____

ХУВААРЬ 1

Төслийн тодорхойлолт

Энэхүү Төслийн зорилго нь Монгол Улсад ажил хайж буй иргэд болон бичил бизнес эрхлэгчид хөдөлмөрийн зах зээл дэх боломжуудыг илүү хүртээмжтэй ашиглах нөхцөлийг сайжруулж, КОВИД-19 цар тахлын хямралын үед шаардлага хангасан хөдөлмөр эрхлэгчдэд түр хугацааны дэмжлэг үзүүлэх явдал юм.

Төсөл нь дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

Бүрэлдэхүүн хэсэг 1. Харилцагч төвтэй төрийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг дэмжих

- (a) Зарим Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдийг шинэчлэх, үүнд: (i) Шинэчилсэн ажлын зохион байгуулалтыг туршиж хэрэгжүүлэх; (ii) Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн систем ба мэдээлэл харилцааны технологид суурилсан ажил зуучлалын хэрэгслүүдийг уялдаа холбоотойгоор туршиж, ашиглах; (iii) ХХҮЕГ-ын орчинг сайжруулах; (iv) төрийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний чадавх бэхжүүлэх;
- (б) Дараах ажлуудад техникийн дэмжлэг үзүүлэх: (i) хувийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний стандарт, ажлын үйл явц ба гүйцэтгэлийн үнэлгээнд дүн шинжилгээ хийх; (ii) төрийн болон хувийн хөдөлмөрийн биржүүд сул ажлын байрны мэдээллийг харилцан хуваалцах, өргөжүүлэх байдлаар уялдаа холбоог сайжруулах; (iii) гол зорилтот бүлгүүдэд сайжруулсан үйлчилгээний талаар сурталчилж, мэдээлэл хүргэх.

Бүрэлдэхүүн хэсэг 2. Төслийн хүрээнд сонгосон хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй хөтөлбөрүүдийг бэхжүүлэх

2.1. Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих

Бичил бизнес эрхлэгчдэд дараах дэмжлэгийг үзүүлнэ:

- (a) бизнесийн ур чадвар олгох болон бизнес хөгжлийн сургалт, тусгай сургалтын модулиуд, зөвлөн туслах үйлчилгээ, бие биенээсээ харилцан суралцах ба төгсөгчдийн сүлжээг үүсгэх, мөн зах зээлд холбох зэрэг санхүүгийн бус дэмжлэгүүд;
- (б) шаардлага хангасан бичил бизнес эрхлэгчид, үйлдвэрлэлүүдэд бичил зээл олгох Оролцогч санхүүгийн байгууллагууд (ОСБ)-д зээлийн шугам нээх замаар санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ.



2.2. Ур чадвар сайжруулах хөтөлбөр

Хөдөлмөрийн зах зээлд үнэлэгдэж байгаа ур чадваруудыг хөгжүүлэх зорилготой ур чадварын шинэлэг хөтөлбөрүүдийг боловсруулж, туршихад техникийн дэмжлэг үзүүлэх.

Бүрэлдэхүүн хэсэг 3. Хөдөлмөрийн зах зээлийн мониторинг, дүн шинжилгээ ба төслийн удирдлагад дэмжлэг үзүүлэх

3.1. Хөдөлмөрийн зах зээлийн мониторинг, дүн шинжилгээ

Дараах бүтээгдэхүүнийг боловсруулж, түгээнэ: (а) 2.2 хэсгийн хүрээнд туршсан ур чадварын шинэлэг хөтөлбөрүүдийн үр нөлөөний үнэлгээг хийх; (б) ажилгүйдлийн судалгаа; ба (в) хөдөлмөрийн зах зээл дэх ажил мэргэжлийн бүтэц, ур чадварын эрэлт хэрэгцээний судалгаа.

3.2. Төслийн удирдлага ба мониторинг

Төслийн өдөр тутмын хэрэгжилт, үүний дотор төлөвлөлт ба гүйцэтгэл, худалдан авалт, санхүүгийн удирдлага, байгаль орчны ба нийгмийн нөлөөллийн менежмент ба хяналт-шинжилгээний үнэлгээний ажлуудад дэмжлэг үзүүлнэ.

Бүрэлдэхүүн хэсэг 4. КОВИД-19 нөхцөл байдлын хариу арга хэмжээний хүрээнд шаардлага хангасан ажиллагсдад түр хугацааны дэмжлэг олгох

Шаардлага хангасан Үр шим хүртэгчдийн нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөрийг нь Нийгмийн даатгалын санд шилжүүлж, түр хугацааны дэмжлэг үзүүлэх.

ХУВААРЬ 2

Төслийн Хэрэгжилт

Хэсэг I. Хэрэгжилтийн зохицуулалт

A. Удирдлагын зохион байгуулалт.

1. Хүлээн авагч нь Ассоциацийн шаардлагад нийцсэн бөгөөд ХЭДС-гийн гарын авлага болон Төслийн үйл ажиллагааны гарын авлагад заасан зохих бүрэлдэхүүн, чиг үүрэг, ажилтнууд болон нөөц бүхий Төсөл хэрэгжүүлэх бүтцийг үндэсний болон орон нутгийн түвшинд Төсөл хэрэгжиж дуусах хүртэлх бүхий л хугацаанд хадгалж ажиллана.
2. Дээр дурдсан нөхцөлийг хангахаас гадна, Хүлээн авагч нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:



- (a) Төслийн хэрэгжилтийн ерөнхий явцыг хянаж, стратегийн удирдлагаар хангах, газар, хэлтэс хоорондын уялдаа холбоог хангах үүрэг бүхий, ХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар удирдуулсан Төслийн удирдах хороог ажиллуулах,
- (б) Ассоциацийн шаардлагад нийцсэн ажлын удирдамжид заасан ур чадвар бүхий Төслийн зохицуулагчаар удирдуулсан, Төслийн өдөр тутмын хэрэгжилтийг хариуцсан Төсөл хэрэгжүүлэх нэгжийг ХНХЯ-ын харьяа ажиллуулах, үүнд: (i) жилийн ажлын төлөвлөгөө, төсвийг бэлтгэх, (ii) худалдан авалт, санхүүгийн удирдлага, байгаль орчин ба нийгмийн нөлөөллийн менежмент хийх, (iii) Төслийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх,
- (в) Ассоциацийн шаардлагад нийцсэн бүрэлдэхүүн, чиг үүрэг, ажилтнууд болон нөөц бүхий техникийн багийг НДЕГ-ын харьяа ажиллуулах. Энэ нь дараах үүргийг биелүүлнэ: (i) Үр шим хүртэгчдийн НД-ын шимтгэл төлөлтийн баталгаажуулалтыг сар бүр хийх; (ii) Төслийн 4 дэх Бүрэлдэхүүн хэсгийн үйл ажиллагаанд хяналт тавьж, ХНХЯ-нд тайлагнах; (iii) Аймаг, дүүргийн түвшин дэх нийгмийн даатгалын байгууллагад техникийн дэмжлэг үзүүлэх.

Б. Төслийн үйл ажиллагааны гарын авлага

Хүлээн авагч нь: а) 2020 оны 9 дүгээр сарын 15-ны өдрөөс өмнө болон Төслийн ямар нэг үйл ажиллагаа эхлэхээс өмнө Төслийн үйл ажиллагааны гарын авлага боловсруулж баталсан байх бөгөөд б) 2020 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр болон төслийн 2.1(б) хэсгийн хэрэгжилтээс өмнө ХЭДС гарын авлагын боловсруулан хэрэглэх ба гарын авлагад заасан зохицуулалт, журмын дагуу Төслийг хэрэгжүүлэх бөгөөд (Төслийн үйл ажиллагааны гарын авлага ба ХЭДС гарын авлага болон энэхүү Хэлэлцээрийн зохицуулалтын хооронд ямар нэг зөрүүтэй байдал үүссэн тохиолдолд энэхүү Хэлэлцээрийн заалтуудыг дагаж мөрдөнө), Ассоциациас урьдчилан бичгээр зөвшөөрөл аваагүй тохиолдолд Төслийн үйл ажиллагааны гарын авлагуудын аль нэг заалтад өөрчлөлт оруулах, хүчингүй болгох, цуцлах зэрэг арга хэмжээ авч үл болно.

В. Жилийн ажлын төлөвлөгөө ба төсөв

1. Хүлээн авагч нь Төсөл хэрэгжүүлэх санхүүгийн жил бүрийн 11 дүгээр сарын 30-ны өдрөөс хойшгүй хугацаанд (эсвэл Ассоциацитай тохирсон үүнээс хойших хугацаанд) ХНХЯ-аар дамжуулан Жилийн ажлын төлөвлөгөө ба төсвийг (ЖАТТ) бэлтгэн Ассоциацийн зөвшөөрөл авахаар ирүүлэх бөгөөд дараагийн санхүүгийн жилд хэрэгжүүлэх Төслийн бүхий л үйл ажиллагаа болон зарцуулалтууд,

тэдгээрийг санхүүжүүлэх эх үүсвэрүүд, энэхүү Хуваарийн Е хэсгийн зохицуулалтын дагуу байгаль орчны болон нийгмийн нөлөөллийн эрсдэлийг бууруулах чиглэлд авч хэрэгжүүлсэн эсвэл хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа арга хэмжээнүүдийг багтаасан байна.

2. Хүлээн авагч нь Төслийг Ассоциацийн зөвшөөрсөн тухайн санхүүгийн жилийн ЖАТТ-ийн дагуу хэрэгжүүлэх бөгөөд ЖАТТ ба энэхүү Хэлэлцээрийн заалтуудын хооронд ямар нэг зөрүүтэй байдал үүссэн тохиолдолд энэхүү Хэлэлцээрийн заалтуудыг дагаж мөрдөнө.
3. Хүлээн авагч нь Ассоциациас урьдчилан бичгээр зөвшөөрөл аваагүй тохиолдолд ЖАТТ-д ямар нэг өөрчлөлт оруулах, хүчингүй болгох, цуцлах зэрэг арга хэмжээ авч үл болно.

Г. Дамжуулан зээлдүүлэх гэрээ

1. Төслийн 2.1(б) хэсгийг хэрэгжүүлэхийн тулд Хүлээн авагч нь ХНХЯ-аар дамжуулан Санхүүжилтийн эх үүсвэрийн тодорхой хэсгийг ХХҮЕГ болон ОСБ хооронд байгуулах дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу ОСБ-д олгох бөгөөд (ийм “Дамжуулан зээлдүүлэх гэрээ” тус бүрийн хувьд) ОСБ нь дараах үүргийг хүлээнэ:
 - а. Дамжуулан зээлдүүлэх гэрээнд заасны дагуу Санхүүжилтийн эх үүсвэрийг зөвхөн Бичил бизнес эрхлэгчдэд бичил зээл олгоход зориулах ба Ассоциацийн шаардлагад нийцсэн бөгөөд ХЭДС-гийн гарын авлагад нарийвчлан тусгасан шалгуур, зааврын дагуу олгоно.
 - б. Бичил бизнес эрхлэгчдэд бичил зээл олгохдоо техник, эдийн засгийн, санхүүгийн болон удирдлагын зохистой практикийн хүрээнд, түүний дотор ХЭДС-гийн гарын авлага, Байгаль орчны болон нийгмийн нөлөөллийн хариуцлагын төлөвлөгөө (БОННХТ)-нд тусгагдсан заалтууд болон Хүлээн авагчаас бусад санхүүжилтийг хүлээн авагчид ногдох авилгын эсрэг удирдамжийн дагуу хэрэгжүүлнэ.
2. Дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу өөрийн эрхээ эдлэхдээ Хүлээн авагч нь өөрийн болон Ассоциацийн эрх ашгийг хамгаалж, Төслийн зорилгыг биелүүлж ажиллана. Ассоциациас урьдчилан зөвшөөрөл аваагүй тохиолдолд Дамжуулан зээлдүүлэх гэрээ болон түүнд тусгагдсан аливаа заалтыг бусдад шилжүүлэх, өөрчлөх, хүчингүй, хэрэгсэхгүй болгох үйлдэл хийж үл болно.

Д. НДС-гийн шимтгэл

1. Төслийн Бүрэлдэхүүн хэсэг 4-ийг хэрэгжүүлэхийн тулд Хүлээн авагч нь ХНХЯ-аар дамжуулан Санхүүжилтийн эх үүсвэрийн зарим нэг хэсгийг Төслийн үйл ажиллагааны гарын авлагад заасан шалгуур,



журмын дагуу холбогдох Үр шим хүртэгчдийн нэрийн өмнөөс Нийгмийн даатгалын санд НД-ын шимтгэл хэлбэрээр төлнө.

2. Энэхүү Хэлэлцээрийн хүрээнд хүлээсэн бусад тайлагнах үүргээс гадна Хүлээн авагч нь ХНХЯ-аар дамжуулан НДС-гийн шимтгэлийн төлбөрийн сар тутмын тайланг Ассоциацийн шаардлагад нийцэх хэлбэрээр гаргаж, Ассоциацид хүргүүлнэ.

Е. Байгаль орчны болон нийгмийн нөлөөллийн шаардлагууд

1. Хүлээн авагч нь Байгаль орчны болон нийгмийн нөлөөллийн стандартын дагуу, Ассоциацийн шаардлагад нийцсэн байдлаар Төслийг хэрэгжүүлнэ.
2. Дээрх 1 дүгээр хэсэгт зааснаас гадна, Хүлээн авагч нь Төслийг Байгаль орчны болон нийгмийн нөлөөллийн хариуцлагын төлөвлөгөө (БОННХТ)-ний дагуу, Ассоциацийн шаардлагад нийцсэн байдлаар хэрэгжүүлнэ. Энэ зорилгын хүрээнд Хүлээн авагч нь дараах үүргийг хүлээнэ:
 - (а) БОННХТ-нд заасан арга хэмжээ, үйл ажиллагааг үр дүнтэй тус төлөвлөгөөнд нарийвчлан заасны дагуу хэрэгжүүлэх;
 - (б) БОННХТ-г хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө хуваарилах;
 - (в) БОННХТ-нд нарийвчлан заасны дагуу БОННХТ-г хэрэгжүүлэхэд шаардлагатай бодлого, журам болон шаардагдах ур чадвар бүхий ажилтнуудаар хангах;
 - (г) Ассоциациас бичгээр зөвшөөрөл авсны дагуу хянан засварласан БОННХТ-г олон нийтэд нээлттэй мэдээллээгүй тохиолдолд БОННХТ болон түүний аль нэг заалтад өөрчлөлт оруулах, хянан засварлах эсвэл хөнгөлөлт үзүүлэх үйлдэл хийж үл болно.
3. БОННХТ болон тус Хэлэлцээрийн заалтуудын хооронд зөрүүтэй байдал үүссэн тохиолдолд энэхүү Хэлэлцээрийн заалтуудыг дагаж мөрдөнө.
4. Хүлээн авагч нь:
 - (а) БОННХТ-нд туссан давтамжийн дагуу БОННХТ-ний хэрэгжилтийн тайланг хүлээн авч нэгтгэн Ассоциацид тусдаа тайлан (тайлангууд) тогтмол хүргүүлэн тайлагнахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авах, Ассоциациас хүссэн тохиолдолд БОННХТ-ийн хэрэгжилт, түүнд заасан удирдлагын болон бусад заалтуудын нийцлийн хэрэгжилтийн явцыг Ассоциацийн шаардлагад нийцсэн хэлбэрээр тайланг гаргаж хүргүүлэх бөгөөд дараах мэдээллийг багтаасан байна: (i) БОННХТ-ний хэрэгжилтийн байдал; (ii) БОННХТ-ний хэрэгжилтэд тулгарч буй

хүндрэл, учирч болох хүндрэлтэй аливаа нөхцөлүүд; (iii) тэдгээр нөхцөлүүдийг шийдвэрлэхийн тулд авч хэрэгжүүлсэн эсвэл авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүд;

- (б) БОННХТ болон дурдагдсан арга хэрэгслүүд, Байгаль орчны болон нийгмийн нөлөөллийн стандартын дагуу байгаль орчин, олон нийт ба ажиллагсдад ихээхэн сөрөг нөлөө үзүүлж байгаа эсхүл үзүүлж болзошгүй Төсөлтэй эсхүл Төсөлд нөлөө үзүүлэх аливаа үйл явдал эсвэл тохиолдлын талаар Ассоциацид нэн даруй мэдэгдэх.
5. Хүлээн авагч нь Төсөлтэй холбоотой гарч болох бүх гомдлуудыг хүлээн авах талбарыг Ассоциацийн шаардлагад нийцсэн байдлаар бий болгон нийтэд мэдээлэх бөгөөд Төслийн талаар гарсан бүх гомдлыг тус талбараар дамжуулан хүлээн авч, Ассоциацийн шаардлагад нийцсэн байдлаар шийдвэрлэнэ.
6. Хүлээн авагч нь Төслийн хүрээнд хийгдэх барилгын ажилтай холбоотой тендерийн бичиг баримт болон гэрээнүүд нь гүйцэтгэгч тал болон туслан гүйцэтгэгч талууд болон хянагч талуудын гэрээний үүрэгт дараах зүйлүүдийг тусгасан байх, үүнд: (а) БОННХТ болон тэнд дурдагдсан байгаль орчин болон нийгмийн нөлөөллийн эрсдэлийг бууруулах арга хэрэгслүүдийг холбогдох заалтуудыг дагаж мөрдөх, (б) байгаль орчин, нийгэм, эрүүл мэндийн болон аюулгүй ажиллагааны эрсдэл, бэлгийн дарамт, мөлжлөг, хүүхдийн эсрэг гэмт хэргээс сэргийлэх ёс зүйн дүрэм нэвтрүүлж, шаардагдах арга хэмжээг хэрэгжүүлэх,

Хэсэг II. Төслийн Хяналт-шинжилгээ, Тайлагнал, Үнэлгээ

A. Төслийн тайлан

Хүлээн авагч нь Төслийн тайланг цаглабарын хагас жил бүрийн дараах дөчин таваас ихгүй хоногийн (45) дотор Ассоциацид хүргүүлнэ.

Б. Дунд хугацааны үнэлгээ

Хүлээн авагч нь: (а) Төсөл хүчинтэй болсон хугацаанаас арван найман (18) сар эсвэл 18 сар орчмын дараа, Ассоциацийн хүссэн хэмжээнд нарийвчилсан дунд хугацааны тайланг бэлтгэн, тус тайлант хугацаанд гарсан ахиц дэвшлийг баримтжуулан, энэхүү II Хэсгийн А хэсэгт заасны дагуу хяналт, шинжилгээ-үнэлгээний үйл ажиллагааг харгалзан, мөн энэхүү өдрөөс цаашид Төслийг үргэлжлүүлэн үр ашигтай хэрэгжүүлэн, төслийн зорилтуудыг хангахад авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийг



багтаана; (б) тайланг хүргэснээс хойш 45 хоног хүртэлх хугацаанд Ассоциацитай хамтран тайланг хянаж, тус тайлангийн дүгнэлт, зөвлөмжүүд болон тухайн асуудлаарх Ассоциацийн дүгнэлтэд үндэслэн Төслийг цаашид үргэлжлүүлэн үр дүнтэй хэрэгжүүлж, төслийн зорилтуудыг хангахад шаардлагатай бүх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

- В.** Ассоциациас тусгайлан хүссэн эсвэл энэхүү Хэлэлцээрт тусгайлан зааж зөвшөөрснөөс өөр тохиолдолд энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 1-т тусгасан үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хуваалцах, тайлагнах, баримтжуулахад Хүлээн авагч нь Хувь хүний мэдээллийг оруулахгүй.

Хэсэг III. Санхүүжилтийн хөрөнгийг татаж авах

А. Ерөнхий зүйл

Хүлээн авагч нь Ерөнхий нөхцөлүүдийн II Бүлгийн заалтууд, Хөрөнгө зарцуулах ба санхүүгийн мэдээллийн захидлын дагуу, Зөвшөөрөгдөх Зардлуудыг санхүүжүүлэх зорилгоор Санхүүжилтийн эх үүсвэрээс доорх хүснэгтэд дурдсан Зарцуулалтын ангилал тус бүрт заасан хувь хэмжээгээр хөрөнгө татан авч болно.

Ангилал	Хуваарилагдсан хөрөнгийн хэмжээ (ЗТЭ-ээр илэрхийлснээр)	Санхүүжигдэх Зарцуулалтын хувь (татвар оролцуулан)
(1) Төслийн Бүрэлдэхүүн хэсэг 1, 2.2 ба 3-ын үйл ажиллагааны бараа, ажил, зөвлөхийн бус үйлчилгээ, зөвлөхийн үйлчилгээ, сургалт ба үйл ажиллагааны зардал	3,310,000	100%
(2) Төслийн Бүрэлдэхүүн хэсэг 2.1- ийн дор хэрэгжүүлэх зөвлөхийн бус үйлчилгээ, зөвлөхийн үйлчилгээ, Сургалт, Бичил зээл	4,040,000	Бичил зээлд зориулан зарцуулсан хөрөнгийн 100% ба бусад Зөвшөөрөгдөх зардлуудад зарцуулсан хөрөнгийн 100%
(3) Төслийн Бүрэлдэхүүн хэсэг 4-ийн дор хэрэгжүүлэх НДС-гийн шимтгэл	7,350,000	Зарцуулсан хөрөнгийн 100%



НИЙТ ДҮН	14,700,000
-----------------	-------------------

Б. Хөрөнгө татах нөхцөл, хугацаа

1. Дээрх А Хэсгийн заалтуудыг үл харгалзан 2020 оны 7 дугаар сарын 1-ний өдөр болон түүнээс хойших хугацаанд Ангилал (1) болон (2) -т багтсан Зөвшөөрөгдсөн зардлуудыг санхүүжүүлэх зориулалтаар нийт ЗТЭ 2,900,000-с хэтрэхгүй зарцуулалтын төлбөр хийхээс бусад тохиолдолд Хэлэлцээрт гарын үсэг зурсан өдрөөс өмнө хийсэн төлбөрт хөрөнгө зарцуулахыг хориглоно
2. Төсөл дуусгавар болох өдөр нь 2023 оны 12 дугаар сарын 31-н байна.

ХУВААРЬ 3

Эргэн төлөлтийн хуваарь

Төлбөр төлөгдөх огноо	Зээлийн эргэн төлөгдөх үндсэн хэмжээ (хувиар илэрхийлэгдсэн)*
2-р сарын 15 болон 8-р сарын 15:	
2025 оны 8-р сарын 15-аас эхлэн 2045 оны 2-р сарын 15-н хүртэл	1.65%
2045 оны 8-р сарын 15-аас эхлэн 2050 оны 2-р сарын 15-н хүртэл	3.40%

* Ассоциаци нь Ерөнхий нөхцөлүүдийн 3.05 (б) Хэсгийн дагуу өөрөөр заагаагүй бол энд тусгагдсан хувь нь Зээлийн эргэн төлөгдөх үндсэн дүнгийн хувийг илэрхийлнэ.

ХУВААРЬ 4

Дамжуулан зээлдүүлэх гэрээний нөхцөлүүд

Энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2, Хэсэг I.Г-д заасан ХХҮЕГ болон ОСБ-ын хооронд байгуулах Дамжуулан зээлдүүлэх гэрээнд дараах нөхцөлүүдийг тусгасан байна. Үүнд:

1. Хүлээн авагч нь өөрийн болон Ассоциацийн эрх ашгийг хамгаалах, үүний дотор ОСБ нь Дамжуулан зээлдүүлэх гэрээний аль нэг үүргээ биелүүлээгүй тохиолдолд ОСБ-д хуваарилагдсан Санхүүжилтийн эх үүсвэр ашиглахыг түдгэлзүүлэх, зогсоох, татан авч зарцуулсан нийт хөрөнгө болон түүний хэсгийг буцаан төлүүлэх эрхтэй байна.
2. ОСБ бүр нь дараах үүргийг хүлээнэ:

- (a) (i) Бичил зээл авах Бичил бизнес эрхлэгчдийг ХЭДС-гийн гарын авлагад тусгасан шалгуур, журам болон Авилгын эсрэг удирдамжийн Хүлээн авагчаас бусад Санхүүгийн эх үүсвэрийг хүлээн авч байгаа талуудад хамаарах заалтууд мөн БОННХТ (тусгагдсан удирдлагын арга хэрэгслүүд)-ийн заалтуудад нийцүүлэн сонгож батлах, (ii) Бичил зээлээр санхүүжих хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг үнэлэх, батлах, хянах, дээрх үйл ажиллагаануудын талаар тайлагнах, (iii) Бичил бизнес эрхлэгчдэд Ассоциацийн шаардлагад нийцсэн бөгөөд ХЭДС-гийн гарын авлагад тусгасан шалгуур, журмын дагуу Бичил зээлийг олгохдоо Бичил бизнес эрхлэгчтэй Ассоциацийн шаардлагад нийцсэн нөхцөл бүхий Бичил зээлийн Хэлэлцээр байгуулсны дагуу зээлийн хөрөнгийг шилжүүлэх;
- (б) Бичил зээлийн Хэлэлцээр тус бүрийн хувьд холбогдох эрхээ хэрэгжүүлэхдээ өөрийн болон Хүлээн авагчийн, мөн Ассоциацийн эрх ашгийг хамгаалах дараах эрхтэй байна. Үүнд:
- (i) Бичил зээлийн Хэлэлцээрээр хүлээсэн аль нэг үүргээ биелүүлээгүй Бичил бизнес эрхлэгчдийн Бичил зээлийн эх үүсвэр ашиглахыг түдгэлзүүлэх, зогсоох, эргэн төлөхийг шаардах, бичил зээлийн нийт хөрөнгө болон түүний хэсгийг буцаан төлүүлэх;
- (ii) Бичил зээл авсан Бичил бизнес эрхлэгч нэг бүрийг Бичил зээлийн хөрөнгөөр санхүүжих үйл ажиллагаань ХЭДС-гийн гарын авлагад тусгасан шалгуур, журам болон Авилгын эсрэг удирдамжийн Хүлээн авагчаас бусад Санхүүгийн эх үүсвэрийг хүлээн авч байгаа талуудад хамаарах заалтууд мөн БОННХТ (тусгагдсан удирдлагын арга хэрэгслүүд)-ийн заалтуудад нийцсэн байхыг шаардах;
- (в) Бичил бизнес эрхлэгч нь ОСБ-тай байгуулсан Бичил зээлийн Хэлэлцээрийн аль нэг үүргийг биелүүлж чадахгүй тохиолдолд Бичил бизнес эрхлэгчийн Бичил зээлийн эх үүсвэрийг ашиглах эрхийг түдгэлзүүлэх, зогсоох, эргэн төлөхийг шаардах, бичил зээлийн нийт хөрөнгө болон түүний хэсгийг буцаан төлүүлэх;
- (г) Бичил зээлийн эх үүсвэрээр санхүүжих бараа, ажил, үйлчилгээг ХЭДС-гийн гарын авлагад заасны дагуу худалдан авах, эдгээр бараа, ажил ба үйлчилгээ нь зөвхөн Бичил зээлийн хүсэлт ирүүлсэн бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зориулалтаар ашиглахыг шаардах;

- (д) Төслийн 2.1(б) хүрээнд хэрэгжүүлж байгаа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны явц, холбогдох Дамжуулан зээлдүүлэх гэрээний үүргийн биелэлт ба энэхүү төсөлтэй холбоотой бусад асуудлын талаар Ассоциацийн болон Хүлээн авагчийн хүсэлтийн дагуу санал бодлоо солилцох, шаардлагатай мэдээллээр хангах;
- (е) Бичил зээлийн зарцуулалт, эргэн төлөлт, Бичил зээлийн хүсэлтийн хамт ирүүлсэн бизнес төлөвлөгөөнд заасан зорилтуудыг хангах чиглэлд гарсан ахиц дэвшлийн талаарх тайлан, үүний дотор байгаль орчин болон нийгмийн нөлөөллийн шаардлага, журмын мөрдөлтийн талаар тайлан бэлтгэж Хүлээн авагчид хүргүүлэх;
- (ё) Холбогдох Дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны ахиц дэвшилд саад болж байгаа эсвэл саад болж болзошгүй аливаа нөхцөл байдлын талаар Ассоциаци болон Хүлээн авагчид нэн даруй мэдэгдэх;
- (ж) Санхүүгийн тооцоо бүртгэл, дансуудыг нягтлан бодох бүртгэлийн зохих практикийн болон ХЭДС гарын авлагын дагуу хөтөлж, холбогдох дансыг Ассоциацийн шаардлагад нийцсэн хөндлөнгийн аудитын байгууллагаар аудит хийлгэж, тайланг Хүлээн авагчид хүргүүлэх, Ассоциаци хүсэлт гаргасан үед аудитын тайланг хүргүүлэх;
- (з) Бичил зээлийн эх үүсвэрийг байршуулах, эргэн төлөлт болон бичил зээлийн хүүгийн төлбөр, бусад төлбөрүүд, зээлийн үндсэн төлбөрийг хүлээн авах тусдаа дансуудыг нээж, санхүүгийн холбогдох журам болон Ассоциацийн шаардлагад нийцсэн нөхцөлүүдийн дагуу бүртгэл хөтлөх, (ii) Дээр дурдсан тусдаа дансуудад байршуулсан бүх зээлийн хөрөнгийг Дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу Хүлээн авагчид төлөх ёстой төлбөрийн үүрэг үүсэх хүртэл Хүлээн авагчийн хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөрийг хөгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэхэд ашиглах;
- (и) Олгосон Бичил зээл бүрийн зээлийн эрсдэлийг хариуцах.

ХАВСРАЛТ

Нэр томьёоны тодорхойлолтууд

1. “Авилгын эсрэг удирдамж” гэж Ерөнхий нөхцөлүүдийн Хавсралтын 5 дахь хэсэгт заасан, 2006 оны 10 дугаар сарын 15-ны өдөр баталсан, 2011 оны 1 дүгээр сар ба 2016 оны 7 дугаар сарын 1-ний өдөр шинэчилсэн Олон Улсын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк, Олон Улсын Хөгжлийн Ассоциацийн зээл, буцалтгүй тусламжийн санхүүжилтээр хэрэгжиж буй төслүүдэд залилан, авилгаас урьдчилан сэргийлж, таслан зогсоох талаарх удирдамж”-ийг хэлнэ.



2. “Үр шим хүртэгч” гэж Хүлээн авагчийн Улсын Их Хурлаас 2020 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр баталсан “Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх” тухай хуулийн дагуу Хүлээн авагчийн нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөгдсөн аливаа ажилтан эсвэл ажил олгогчийг хэлэх бөгөөд; энэхүү Үр шим хүртэгч хүмүүсийг хамтад нь “Үр шим хүртэгчид” гэж хэлнэ.
3. “КОВИД-19” гэж 2019 шинэ коронавирус (SARS-CoV-2) -ээс үүдэн гарсан коронавирусын өвчнийг хэлнэ.
4. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн гарын авлага” буюу “ХЭДС-гийн гарын авлага” гэж Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөрийн хүрээнд боловсруулсан, Төслийн 2.1(б) Хэсгийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбоотой Хүлээн авагчийн дүрэм журам, удирдамжийн дагуу боловсруулагдаж батлагдсан бөгөөд Ассоциаци хүлээн зөвшөөрсөн, Ассоциацитай зөвшилцсөний дагуу тухай бүр шинэчилж болох гарын авлагыг хэлнэ.
5. “Байгаль орчны болон нийгмийн нөлөөллийн хариуцлагын төлөвлөгөө” буюу “БОННХТ” хэмээх товчлол нь Хүлээн авагчийн зүгээс Төслийн байгаль орчин ба нийгмийн эрсдэлүүд, сөрөг нөлөөллийг багасгах бодит арга хэмжээ, үйл ажиллагааны нэгтгэл бүхий, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээний цаг хугацаа, удирдлага, ажилтан, сургалт, хяналт-шинжилгээ ба тайлагналтын зохицуулалтууд болон шаардлагатай бусад арга хэрэгслийг багтаасан, Хүлээн авагчийн 2020 оны 5 дугаар сарын 27-ны өдөр баталсан, Ассоциацийн шаардлагад нийцсэн, төлөвлөгөө бөгөөд тус БОННХТ-г Ассоциациас урьдчилан бичгээр зөвшөөрөл авсны дүнд тухай бүр хянан засварлаж болох бөгөөд үүнд тус төлөвлөгөөний хавсралтууд, хуваариуд мөн хамаарна.
6. “Байгаль орчны ба нийгмийн нөлөөллийн стандартууд” гэдэгт 2018 оны 10 дугаар сарын 1-нээс мөрдөгдөж, Ассоциацийн <https://www.worldbank.org/en/projects-operations/environmental-and-social-framework> -сайтаар нийтэлсэн (i) “Орчны болон Нийгмийн стандарт 1: Байгаль орчин ба Нийгмийн эрсдэлүүд, үр нөлөөний үнэлгээ ба удирдлага”; (ii) “Орчны болон Нийгмийн стандарт 2: Хөдөлмөр ба ажиллах орчин”; (iii) “Орчны болон Нийгмийн стандарт 3: Нөөцийн зохистой ашиглалт ба бохирдлоос сэргийлэх менежмент”; (iv) “Орчны болон Нийгмийн стандарт 4: Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал”; (v) “Орчны болон Нийгмийн стандарт 5: Газар авах, Газар ашиглалтын хязгаарлалтууд ба албадан нүүлгэх”; (vi) “Орчны болон нийгмийн стандарт 6: Биологийн төрөл зүйлийг хамгаалах ба байгалийн амьд нөөцийн тогтвортой менежмент”; (vii) “Орчны болон нийгмийн стандарт 7: Уугуул иргэд Үйлчилгээ хүрч очдоггүй

- Африкийн Дэд-Сахарын уламжлалт орон нутгийн иргэд”; (viii) “Орчны болон нийгмийн стандарт 8: Соёлын өв”; (ix) “Орчны болон нийгмийн стандарт 9: Санхүүгийн зуучид”; (x) “Орчны болон нийгмийн стандарт 10: Оролцогч талуудын оролцоо ба Мэдээллийг нийтэд ил болгох” стандартуудыг хамтад нь ойлгоно.
7. “Ерөнхий нөхцөлүүд” гэж 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдөр батлагдсан, “Олон улсын хөгжлийн ассоциацийн санхүүжилт, Хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилтийн тухай Олон улсын хөгжлийн ассоциацийн Ерөнхий нөхцөлүүд ”-ийг хэлнэ.
 8. ХХҮЕГ гэж Хүлээн авагчийн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа байгуулагдан үйл ажиллагаа явуулж буй Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар эсвэл түүний залгамж байгууллагыг ойлгоно.
 9. “Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс” гэж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, эсвэл түүний залгамж байгууллагын дор харьяалагдах хөдөлмөр, халамжийн үйлчилгээ хариуцсан газар, хэлтсүүдийг нийтэд нь “Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүд” гэж нэрлэнэ.
 10. “Бичил бизнес эрхлэгч” гэж Хүлээн авагчийн 2011 оны 6 дугаар сарын 17-ны өдөр баталж, тухай бүр нэмэлт, өөрчлөлт орсон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд заасны дагуу үйлдвэрлэл эсвэл үйлчилгээний үйл ажиллагаа явуулахаар бүртгүүлсэн аж ахуйн нэгж эсвэл хувь хүнийг хэлэх бөгөөд; эдгээр бүх бичил бизнес эрхлэгчдийг хамтад нь “Бичил бизнес эрхлэгчид” гэнэ.
 11. “Бичил зээл” гэж Төслийн Санхүүжилтийн эх үүсвэрээс Оролцогч санхүүгийн байгууллагаар дамжуулан ХЭДС-гийн гарын авлагад заасан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг санхүүжүүлэх зориулалтаар Бичил бизнес эрхлэгчдэд олгох бичил зээлийг хэлэх бөгөөд, энэхүү зээлийг нийтэд нь “Бичил зээлүүд” гэнэ.
 12. “Бичил зээлийн Хэлэлцээр” гэж Бичил бизнес эрхлэгчийн бизнесийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх зорилгоор ОСБ ба Бичил бизнес эрхлэгчийн хооронд байгуулсан зээлийн Хэлэлцээрийг хэлэх бөгөөд ийм бичил зээлийн Хэлэлцээрүүдийг хамтад нь “Бичил зээлийн Хэлэлцээрүүд” гэнэ.
 13. “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж Хүлээн авагчийн хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудлыг хариуцсан яам эсвэл түүний залгамж байгууллагыг хэлнэ.
 14. “Дамжуулан зээлдүүлэх гэрээ” гэж Хүлээн авагчийг төлөөлөн ХХҮЕГ ба ОСБ-ын хооронд энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 4-т заасны



дагуу Ассоциацийн шаардлагад нийцэх нөхцөлүүдтэй байгуулсан гэрээг хэлэх ба ийм дамжуулан зээлдүүлэх гэрээнүүдийг хамтад нь “Дамжуулан зээлдүүлэх гэрээ” гэнэ.

15. “Үйл ажиллагааны зардлууд” гэж Төслийн үйл ажиллагааны өдөр тутмын зохицуулалт, хэрэгжилт, удирдлага хяналт хийхэд шаардагдах бараа болон зөвлөхийн бус үйлчилгээний зохих хэмжээний зардлууд бөгөөд үүнд машин, тоног төхөөрөмж, оффисийн байрны түрээс, эсвэл тогтмол засвар үйлчилгээ, шатахуун, оффисийн материал, бичгийн хэрэгсэл, нийтийн аж ахуйн үйлчилгээний төлбөр, хэрэглээний зүйлс, харилцаа холбооны үйлчилгээ (үүнд шуудан илгээх, утас, интернетийн зардал орно), тээвэр, орчуулга, хэвлэх, олшруулах зардал, банкны хураамж, нийтлэл, зар сурталчилгааны зардал, даатгал, Төсөлтэй холбоотой уулзалтын зардлууд, томилолтын зардал, гэрээгээр нэмэлт дэмжлэг үзүүлж байгаа ажилтны болон Төсөлтэй холбоотой захиргааны бусад шууд зардлууд багтах бөгөөд үүнд Хүлээн авагчийн төрийн албаны ажилтны цалин урамшуулал, эсвэл үүнтэй адилтгах орлого хөлс орохгүй.
16. “Хувь хүний өгөгдөл” гэж тухайн хувь хүнийг нь тогтоосон эсвэл тогтоох боломжтой аливаа мэдээллийг хэлнэ. Олж тогтоох боломжтой хүн гэж шууд болон шууд бус аргаар, өгөгдөл дотор агуулагдаж байгаа аль нэг шинж чанар эсвэл шинж чанаруудын нэгдлээр, эсвэл бусад ашиглах боломжтой мэдээллийн өгөгдлийн нэгдлээр дамжуулан тогтоох боломжтой хувь хүнийг хэлнэ. Олж тогтоох боломжтой хувь хүнийг тодорхойлоход ашиглагддаг шинж чанаруудад нэр, регистрийн дугаар, байршлын өгөгдөл, цахим таних тэмдэг (и-мэйл хаяг гм), мета өгөгдөл болон хувь хүний материаллаг, бие физиологийн, удам гарлын, оюуны, эдийн засгийн, соёлын эсвэл нийгмийн шинж чанаруудтай холбоотой хүчин зүйл зэргийг багтаах бөгөөд зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй.
17. “Оролцогч санхүүгийн байгууллага” эсвэл “ОСБ” гэж Хөдөлмөр Эрхлэлтийг Дэмжих Сангийн гарын авлагад заасан шаардлагуудыг хангасан, Хүлээн авагчийн сонгосон, төслийн 2.1 (б) хэсгийн хүрээнд бичил зээл олгох санхүүгийн байгууллагыг хэлэх бөгөөд ийм байгууллагуудыг хамтад нь “Оролцогч санхүүгийн байгууллагууд” гэж хэлнэ.
18. “Худалдан авах ажиллагааны журам” гэж Ерөнхий нөхцөлүүдийн Хавсралтын 87 дахь хэсгийн хувьд 2016 оны 7 дугаар сард баталсан “Хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилтийн зээлдэгчдэд зориулсан Дэлхийн банкны худалдан авалтын журам”-ыг хэлнэ (2017 оны 11 дүгээр сар ба 2018 оны 8 дугаар сард хянан засварласан).

19. “Төслийн үйл ажиллагааны гарын авлага” гэж энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын I.Б Хэсэгт заасан Төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зориулан Хүлээн авагчийн бэлтгэж батлах гарын авлагыг хэлэх бөгөөд, үүнд дараах нарийвчилсан зохицуулалт, журмуудыг оруулсан байна: “ (а) Төслийн удирдлагын зохицуулалт ба өдөр тутмын хэрэгжилт; (б) зарцуулалт ба санхүүгийн удирдлага; (в) худалдан авалт; (г) байгаль орчны болон нийгмийн хамгааллын арга хэмжээнүүд; (д) хяналт-шинжилгээ ба үнэлгээ, тайлагналт ба харилцаа холбоо; (е) шударга байдлыг хангах төлөвлөгөө, (ё) Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн гарын авлага; ба (ж) хувь хүний мэдээллийг олон улсын сайн туршлагад нийцсэн байдлаар цуглуулах, дамжуулахтай холбоотой Төслийн хэрэгжилтийн хүрээн дэх үүрэг, хариуцлага; (з) Төслийн хэрэгжилтэд шаардагдах энэ мэт захиргааны, санхүүгийн, техникийн ба зохион байгууллалтын бусад зохицуулалт журмууд; энэ гарын авлага нь Ассоциациас урьдчилан бичгээр өгсөн зөвшөөрөл дээр үндэслэн тухай бүр шинэчлэгдэж болох ба, үүнд тус гарын авлагын бүх хуваариуд мөн хамаарна.
20. “Төсөл хэрэгжүүлэх нэгж” гэж Хүлээн авагчийн энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын I.А Хэсгийн 2(б) зүйлд заасны дагуу байгуулж ажиллуулах нэгж бөгөөд түүний залгамжлагчийг хэлнэ.
21. “Төслийн Удирдах Хороо” гэж энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын I.А. Хэсгийн 2 (а) зүйлд заасны дагуу Хүлээн авагчийн байгуулж, ажиллуулах удирдах хороог хэлнэ.
22. “Гарын үсэг зурах өдөр” гэж Хүлээн авагч болон Ассоциаци энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурсан хоёр өөр өдрийн сүүлийнхийг хэлэх бөгөөд энэхүү тодорхойлолт нь Ерөнхий нөхцөлүүдэд гарах бүх “Санхүүжилтийн Хэлэлцээрийн огноо”-нд хамаарна.
23. “Нийгмийн даатгалын сан” буюу “НДС” гэж Хүлээн авагчийн 1994 оны 5 дугаар сарын 14-нд баталж, нэмэлт, өөрчлөлтүүд оруулсан Нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу байгуулагдаж, үйл ажиллагаа явуулдаг санг хэлнэ.
24. “НДЕГ” гэж ХНХЯ-ны харьяа байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж буй Хүлээн авагчийн Нийгмийн даатгалын ерөнхий газрыг, түүний залгамжлагчийг хэлнэ.
25. “НДС-гийн шимтгэл” гэж Хүлээн авагчийн Нийгмийн даатгалын санд шаардлага хангасан Үр шим хүртэгчийн нэрийн өмнөөс шимтгэл хэлбэрээр Санхүүжилтийн эх үүсвэрээс төлөх дэмжлэгийг хэлэх бөгөөд; ингэж төлөгдсөн бүх НДС-гийн шимтгэлийг нийтэд нь “НДС-гийн шимтгэлүүд” гэж хэлнэ.



26. “Сургалт” гэж Төслийн хүрээнд холбогдох ажилтнуудыг сургалтын үйл ажиллагаа, семинар, танилцах аялалд оролцуулахад шаардагдах бараа, үйлчилгээний зардлууд, үүнд сургалт семинар, танилцах аялалд оролцогчдын замын, томилолтын зардал, сургагч багш нарын зардал, сургалт семинарын тоног төхөөрөмж болон байрны түрээсийн зардал, сургалт семинарын материал боловсруулах, олшруулах зардлууд болон сургалт семинар, танилцах аяллыг зохион байгуулахтай шууд холбоотой бусад зардлуудыг хэлэх боловч үүнд зөвлөхийн ажлын хөлс болон Хүлээн авагчийн төрийн албан хаагчдын цалин, урамшуулал, эдгээртэй адилтгах шагнал, бусад хөлс хамаарахгүй.

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1.75

Индекс: 200003